

БАТЛАВ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, “ИРГЭДИЙН ОРОЛЦОО II” ТӨСЛИЙН ЗАХИРАЛ



Г.БИЛГҮҮН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ХУУЛЬ ЗҮЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ, УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2019.10.28

А. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр”-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо II” төсөл нь иргэдийн оролцооны хууль, эрх зүйн орчныг сайжруулах, олон нийтэд иргэний оролцооны хууль, эрх зүйн мэдлэг олгох үйл ажиллагааг дэмжих зорилттойгоор ажиллаж байна.

Б. ЗОРИЛГО

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн танилцуулга”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалал”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох эрх” гэсэн 4 үндсэн сэдвээр хууль зүйн мэдлэг олгох сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад оршино.

В. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ

Зөвлөх байгууллага нь дараахь ажил, үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн танилцуулга;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалал;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох эрх;

гэсэн 4 үндсэн сэдвээр хууль зүйн мэдлэг олгох сургалт, уулзалтыг 500-аас доошгүй хүн /хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагачид/-ийг хамруулан, өдрийн 8 цагт багтаан, 2 удаагийн цайны завсарлага, үдийн хоолтойгоор, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сонсголын болон дохионы хэлийг ашиглан зохион байгуулж сургалтад хамрагдсан иргэдийн сонирхсон асуултад хариулт, зөвлөгөө өгнө.

Сургалтын хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Дээрх үндсэн 4 сэдвийн хүрээнд бэлтгэсэн хичээл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ойлгомжтой дуу, дүрс, зураг хуудас, дохионы хэлний хэлбэрээр хийгдсэн байна.

Төслийн нэгж нь гүйцэтгэгчийг холбогдох мэдээллээр хангана.

Г. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА

Дээрх ажлыг гүйцэтгэх хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байх;
- Сүүлийн 2 жилд энэ чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулсан байх;
- Энэ чиглэлийн сургалтын хөтөлбөртэй байх;
- Сургалтыг удирдан явуулах мэргэшсэн сургагч багштай байх;
- Техник, тоног төхөөрөмжийн чадвартай байх;

Д.ХУГАЦАА

Гэрээт ажлыг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Е.ТӨСӨВТ ӨРТӨГ

Төсөвт өртөгт 30 000 000 /гучин сая/ төгрөг байх ба Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аливаа татвар, шимтгэл энэ үнийн дүнд багтсан болно. Ажил гүйцэтгэх гэрээнд 2 тал харилцан гарын үсэг зурсны дараа ажлын 5 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 50 хувийг, Захиалагч тал гэрээнд заасан ажлыг хангалттай хэмээн хүлээн авсны дараа үлдэгдэл 50 хувийн төлбөрийг шилжүүлнэ.

/500-аас дээш хүний багтаамжтай сургалтын танхимыг түрээсээр ашиглаж болно/

Ё.ТАЙЛАГНАХ

Захиалагч тал эцсийн тайланг хангалттай хэмээн хүлээн авч, ажил хүлээн авах актад гарын үсэг зурж баталгаажуулснаар ажил гүйцэтгэх гэрээ дуусгавар болно.

Ж. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Зөвлөх нь дараахь материалыг бүрдүүлэн “Иргэдийн оролцоо II” төслийн нэгжид хаяглан хүргүүлнэ. Үүнд:

- Хуулийн этгээдийн танилцуулга;
- Зөвлөх багийн танилцуулга;

- Сүүлийн 32жилд хийсэн ажлын танилцуулга;
- Сургалтын хөтөлбөр, гарын авлага;
- Үнийн санал;
- Төсвийн задаргаа.

Захиалагчийн хаяг: “Иргэдийн оролцоо II” төслийн нэгж, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хуульчдын гудамж 1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 14201, Монгол Улс, Утас: +976-70008688, Цахим шуудан. tuguldurzaya@legalinstitute.mn